

**БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ-ЫН
“ИРГЭДИЙН АМЬДРАХ ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ ЖИЛ”-ИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ**

2020 оны 06 дугаар сарын 10-ны өдөр

Багануур дүүрэг

| № | “Иргэдийн амьдрах орчныг сайжруулах жил”-ийн ажлын төлөвлөгөө | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Гүйцэтгэл | Хувь |
|----|--|---|--|------|
| 1. | Мод тарих үндэсний өдрөөр ногоон байгууламж бүхий газруудад иргэд, ААНБ-тай хамтран, төрөл бүрийн тарьц, суулгац тарих ажлыг зохион байгуулна. | Мод тарих үндэсний өдрийг тохиолдуулан хамт олноороо мод тарих ажилд идэвхтэй оролцох | <ul style="list-style-type: none"> - Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан иргэдийн бөөгнөрөлийг үүсгэхийг хориглосон тул Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 2010 оны 63 дугаар зарлигийг хэрэгжүүлэн албан хаагчид гэр хороололд амьдардаг байгууллагын 3 ажилтны гэрийн хашаанд мод тарьж арчилгаа усалгааг хийсэн. - Дүүргийн Засаг даргын А/190 дүгээр захирамжийн хүрээнд зохион байгуулагдсан “Мод тарих өдөр”-ийн үйл ажиллагаанд албан хаагчид биечлэн оролцож чадаагүй тул Ойн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх заалтын дагуу хандивын мөнгө цуглуулан дүүргийн Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд тушааж баримтыг Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын 2020 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 93 дугаартай албан бичгээр мөн албан бичигт заагдсан цахим шуудангийн хаягаар тус тус хүргүүлэв. | 100% |
| 2. | Дүүргийн нутаг дэвсгэрийн орчны хог хаягдлыг бууруулж иргэдийн ая тухтай ажиллаж, амьдрах орчныг бүрдүүлэх, бүх нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах | Бүх нийтийн их цэвэрлэгээнд хамт олноороо идэвхтэй оролцох | <p align="center">Багануур дүүргийн Захирагчийн ажлын албанаас 2020 онд зохион байгуулсан бүх нийтийн их цэвэрлэгээнд хамт олноороо идэвхтэй оролцож хуваарилсан газрыг цэвэрлэж, тайланг хүргүүлэн ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - 2020.02.15-ны өдөр “Хоггүй шинэлцгээ” аяны хүрээнд Сар шинийн баярыг угтсан бүх нийтийн их цэвэрлэгээ - 2020.04.04-ний өдөр Хаврын бүх нийтийн их цэвэрлэгээ - 2020.05.02-ны өдөр “Их цэвэрлэгээ – 90 минут” бүх нийтийн их цэвэрлэгээ - 2019.05.23-ны өдөр “Ногоон бүс”-ийн цэвэрлэгээ | 100% |
| 3. | Хог хаягдлын талаар сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах | Хог хаягдлыг бууруулах чиглэлээр арга хэмжээ зохион байгуулах | <ul style="list-style-type: none"> - Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлж айл өрх, тариаланчид болон жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид компост бордоог үйлдвэрлэж нэвтрүүлснээр импортын өндөр үнэтэй бараа бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэж, ашиглах боломж суурийг тавих зорилгоор “Багануур эко хот” төслийн хүрээнд “Багануур тохижилт” ОНӨААТҮГ-тай хамтын ажиллагааны төлөвлөгөөтэй ажиллаж байна. - Тус байгууллагад Үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлаар эрдэст компост бордоо хийж ашиглах сонирхолтой айл өрхүүдэд аргачлалыг заах, зөвлөмж өгөх материалуудыг боловсруулан хүргүүлж, 2 удаагийн танхимын сургалтаар 40 гаруй ажиллагсад, үзүүлэх сургалтад 13 хүнийг хамруулсан. 2019 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр Үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлаар хийсэн компост | 100% |

| | | | | |
|--------------------|--|--|---|--|
| | | | <p>бордоог “Багануур тохижилт” байгууллагын төв магистраль автозам дагуух хамгаалалтын зурвасын модны тариалалтад ашигласан. Ургалтын явцад 2020 оны 03 болон 06 дугаар саруудад хяналт тавьж ажилласан.</p> <ul style="list-style-type: none"> - Парк Багануур дүүргээ Эко-Хот болгох санаачилгын хүрээнд хог хаягдлыг бууруулах чиглэлээр дүүргийн Аж ахуйн нэгж, албан байгууллагуудад “Үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлаар эрдэст, компост бордоо хийх аргачлал” сэдэвт танхимын сургалтыг үйлдвэрлэл технологийн албаны инженер мэргэжилтнүүд 10 дугаар сараас эхлэн 20 байгууллагын 400 гаруй албан хаагчдад зохион байгуулсан. 2020.01.21-ний өдөр Багануур сувилал ХХК-ийн 80 гаруй албан хаагчдад танхимын сургалтыг явуулсан ба Корона вирусын цар тахалын улмаас 4 байгууллагын танхимын сургалт тодорхойгүй хугацаагаар хойшлоод байна. - 2018-2019 онуудад үзүүлэх сургалт хийсэн 6 айл өрхийн компост бордоог 2020 оны 05 дугаар сард газар дээр нь үзэж танилцан, зөвлөгөө өгч ажилласан. - 2020 оны 03 сарын 04-ний өдөр цэвэрлэх байгууламжийн лагийг бордоо болгон үйлдвэрлэх технологийн мэдээллийг “Эко Тайхи” ХХК-ий менежер Ш.Болдсайхан-аас авч, хог хаягдлаар бордоо үйлдвэрлэдэг технологитой хоршуулах боломжийн талаар санал солилцов. | |
| ДУНДАЖ ХУВЬ | | | 100% | |

ХЯНАСАН:

БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК

ОНӨТҮГ-ЫН ДАРГА



Ч.ЭЛБЭГСАЙХАН

ТАЙЛАН ГАРГАСАН:

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Lasurit

Б.НОМИНЗУЛ